



Бурхан бол Алдрын Хаан Залбирлын Хуудас

Огноо:

- Залбирлын хуудсыг хүн бүрт хувилж өгнө
- Цагтаа эхэлж, цагтаа дуусгана
- Хэрэгтэй зүйлс: Библи, *Ээжүүд Хамтдаа Залбирах нь Товхимол*, үзэг.

♥ **Магтаал** — Бурханыг **Хэн болохынх нь** төлөө, Түүний мөн чанар, Түүний нэр эсвэл Түүний зан чанарынх нь төлөө магтана. Энэ мөчид залбирлын хариулт болон залбирлын хүсэлтүүдээ хэлэхгүй.

Мөн чанар: Бурхан бол Алдрын Хаан

Attribute: God Is the King of Glory

Тодорхойлолт: Хүчирхэг Нэгэн; Аугаа хүндлэл магтаал хүртэх зохистой Нэгэн.

Эшлэл(үүд):

- **Дуулал 24:7-10** Сүр жавхлангийн Хаан орж ирлээ, Гүлдан хаалганууд аа, толгойгоо өргөж, Мөнхийн үүднүүд ээ, өргөгдөгтүн! Сүр жавхлангийн энэ Хаан хэн бэ? Хүчтэй, чадалтай ЭЗЭН, Тулалдаанд чадалтай ЭЗЭН буюу. Сүр жавхлангийн Хаан орж ирэхийн тулд Гүлдан хаалганууд аа, толгойгоо өргөж, Мөнхийн үүднүүд ээ, өргөгдөгтүн! Сүр жавхлангийн энэ Хаан хэн бэ? Түг түмдийн ЭЗЭН, Тэрээр сүр жавхлангийн Хаан болой.
- **Лук 19:38** —Эзэний нэрээр ирэгч Хаан ерөөлтэй еэ! Амар тайван нь тэнгэрт, Алдар сүр нь хамгийн дээр байх болтугай! гэж байлаа.
- **1 Тимот 1:17** Эрин үеүдийн Хаан, мөхөшгүй, үл үзэгдэх цор ганц Бурханд хүндлэл ба алдар нь үеийн үед байх болтугай. Амен.

♥ **Гэмшил** — Уучилж өршөөдөг Бурханд хандан гэм нүглээ чимээгүй улайх.

Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх л зөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ. 1 Иохан 1:9

♥ **Талархал** — **Хийсэн зүйлийх нь** төлөө Бурханд талархах. Энэ цагт залбирлын хүсэлтээ хэлэхгүй байх хэрэгтэй. *Бүх зүйлд талархлаа илэрхийл. Учир нь энэ бол та нарын төлөөх Христ Есүс доторх Бурханы хүсэл мөн. 1 Тесалоник 5:18*

♥ **Зуучлан залбирал** — Бурханы өмнө ирж бусдын төлөө залбирах. Хоёр буюу гурваар бүлэгт хуваагдана.

Өөрсдийн хүүхдүүдийн төлөө — Ээж бүр нэг хүүхэд сонгоно. (Библийн ишлэлээр залбирах/Залбирлын тодорхой хүсэлт)

Эшлэл(үүд): Дуулал 145:11-12

Библийн эшлэлээр залбирах:

(Хүүхдийн нэр) маань Таны Хааянлал, Хүч чадлын алдрын тухай ярих болтугай, тэгснээр бүгд Таны хүчирхэг үйлс болон Хаанчлалын тань алдарт сүр жавхланг мэдэх болно.

Залбирлын тодорхой хүсэлт:

Багш/Ажилчид (нэгийг сонгоно): Багш/Ажилтаны төлөө залбирах нэг эшлэл сонго. Дараа нь тодорхой нэг хүсэлтийн дагуу залбирна.

- Эзэн минь ээ Та _____-ний нүдийг нээж, түүнийг харанхуйгаас гэрэл уруу, Сатаны эрхшээлээс Бурхан уруу эргүүлээч. Тэгснээрээ тэд Таньд итгэх итгэлээр ариусгагдсан хүмүүсийн дунд нүглийн уучлал ба өвийг хүртэх болно. *Үйлс 26:18*
- _____ маань Таны Хааянлал, Хүч чадлын алдрын тухай ярих болтугай, тэгснээр бүгд Таны хүчирхэг үйлс болон Хаанчлалын тань алдарт сүр жавхланг мэдэх болно. *Дуулал 145:11-12*

Сургуулийн төлөө залбирах – Сургуулийн орчинд сэргэлт ирж, сүнсний хараа өгөгдөхийн төлөө (цаг байвал хамгаалалт гэх мэт өөр бусад сэдвүүдийн төлөө)

Ээжүүд Хамтдаа Залбирах нь үйлчлэлийн төлөө залбирах — Сургууль бүрийг залбирлаар хучих; үйлчлэлийг хамгаалж өө сэвгүй, цэвэр ариунаар хадгалах.

Бүлэгт залбирсан бүхэн зөвхөн бүлэг дотроо л үлдэх ёстойг анхаараарай!